

Ундай Голын Гольдролыг Өөрчлөхтэй Холбоотой Гомдол
Хөндлөнгийн Шинжээчдийн Баг
Хамтран баримт олж тогтоох үйл ажиллагааны¹ Ажлын төлөвлөгөө болон Аргачлал
1-р шат (2013 оны 10 дугаар сар – 2014 оны 5 дугаар сар)

(2013 оны 12 дүгээр сарын 6-нд батлав)

Танилцуулга ба ерөнхий зүйл

2013 оны 2 дугаар сард Монгол Улсын Өмнийн Говь дахь Оюу Толгой уурхайн (цаашид “Төсөл” гэх) ойролцоо оршин суудаг нутгийн малчид болон ард иргэд орон нутгийн “Говийн газар шороо” ТББ, мөн үндэсний хэмжээний “ОТ Хяналт” ТББ-ын дэмжлэгтэйгээр Эрх Зүйн Хяналт, Зөвлөгөө, Омбудсмэний Газарт (цаашид “CAO” гэх)² хандан Ундай голын гольдролыг өөрчлөх, Бор овоогийн задгайг шилжүүлэхээр Төсөл төлөвлөсөнтэй холбогдуулан гомдол гаргасан болно. CAO-ын Омбудсмэн/Маргааныг шийдвэрлэх үйл ажиллагааны хүрээнд эдгээр асуудлууд болон Ундай голын чухал цутгалан болох Халив-Дугатын голын³ гольдролыг өөрчлөхтэй холбоотой асуудлуудыг судлуулж CAO болон кейсийн талууд болох Малчдын Төлөөлөгчид (цаашид “МТ” гэх) болон Оюу Толгой ХХК (цаашид “ОТ” гэх)-д дүгнэлт зөвлөмжөө гарган танилцуулах Хөндлөнгийн Шинжээчдийн Баг (цаашид “Шинжээчдийн Баг” гэх) ажилуулахаар боллоо. Энэ баримт бичиг нь 2013 оны 8-р сарын 9-ний Хамтарсан Уулзалтаар бүх оролцогч талуудын (CAO, МТ, ОТ) хүлээн зөвшөөрсөн Хөндлөнгийн Шинжээчдийн Багийн Ажлын Удирдамжийн хавсралт болно. Ажлын төлөвлөгөө нь ХШБ-ийн ажлыг гомдлын талуудад илүү тодорхой болгоход оршино.

Үйл ажиллагааны зорилго

ХШБ-ийн Хамтран баримт олж тогтоох үйл ажиллагааны зорилго нь дараахь зүйлсийг үнэлэхэд оршино:

- a) Усны гурван чухал эх үүсвэрт төслөөс учруулж буй нөлөө—Ундай гол, Бор Овоогийн задгай, Халив-Дугатын гол болон
- b) Тухайн үр дагавар нь малчдын бэлчээрийн нөөц, усан хангамж болон усны чанарт хэрхэн нөлөөлж байгаа.

Үнэлгээгээр дараахь зүйлсийг тодорхойлно:

1. ОТ ХХК-с ирүүлсэн дараахь зүйлсийн нөлөөллийн талаарх мэдээлэл болон дүн шинжилгээ нь үнэн зөв эсэх:
 - a) Ундай голын гольдролын өөрчлөлт,
 - b) Бор Овоогийн задгайн нүүлгэн шилжүүлэлт
 - c) Хаягдал хүдрийг агуулах байгууламжийн барилгын ажил, үйл ажиллагаа болон хаягдал чулууны овоолго болон

¹ Хамтран Баримт Олж Тогтоох гэдэг нь бүх оролцогч талуудын нүдэн дээр судалгааг итгэл үнэмшилтэй, үнэн зөв бодитой хийх явдлыг илүү хангах замаар шинжлэх ухааны судалгаа хийх эсвэл хийгдсэн судалгаануудыг нэгтгэх үйл ажиллагаа юм.

² CAO нь Дэлхийн Банкны Группын Олон Улсын Санхүүгийн Корпораци (ОУСК) болон Олон Талт Хөрөнгө Оруулалтын Даатгалын Байгууллагат (ОТХОДБ) хөндлөнгийн хараат бус дэмжлэг туслалцаа үзүүлэх механизм юм. Нэмэлт мэдээллийг <http://www.cao-ombudsman.org/>-ээс үзнэ үү.

³Зарим малчид энэ голыг Халив гол, нөгөө хэсэг нь Дугат гол ч гэдэг. Ойлгомжтой байлгах үүднээс энд туждаа “Халив-Дугатын гол” хэмээн нэрлэлээ.

2. Малчдын бэлчээрийн нөөц, усны хангамж болон усны чанарт нөлөө үзүүлэхгүй байх эсвэл бага нөлөө үзүүлэх өөр хувилбарууд, өөрчлөлтүүд эсвэл нөлөөллөөс зайлсхийх эсвэл нөлөөллийг бууруулах нэмэлт арга хэмжээнүүд байгаа/байсан эсэх.

Хамтран баримт олж тогтоох судалгааны ажлыг 2 үе шаттай хийж гүйцэтгэнэ.

1-р шатанд ХШБ нь дараахь асуудлаар судалж дүгнэлт, зөвлөмж гаргана. Тухайлбал:

- Ундай голын гольдролын өөрчлөх зураг төсөл болон барилгын ажил нь Ундай голын малчдын хэрэгцээг өмнө нь хангаж байсан шиг хэмжээний, чанартай усаар хангаж байгаа эсэх;
- Ундай голын гольдролын өөрчлөлтөөс үүдэн малчдын бэлчээр, усны хангамж болон усны чанарт учирч буй шууд, шууд бус, хам нөлөө; болон
- Ундай голын гольдролын өөрчлөлт болон малчдын бэлчээр, усны хангамж болон усны чанарт нөлөө үзүүлэхгүй байх/ эсвэл нөлөөг багасгах тохиромжит өөр хувилбарууд, өөрчлөлтүүд болон/эсвэл үүнтэй холбоотой мониторингийн болон нөлөөллөөс зайлсхийх эсвэл нөлөөллийг бууруулах төлөвлөгөө

Бор Овоогийн задгайг нүүлгэн шилжүүлэхээр төлөвлөж байгаа газрын хувьд ялангуяа:

- Бор Овоогийн Задгайг нүүлгэн шилжүүлэхээр санал болгосон дизайн загварын зохимжит байдал болон үндсэн задгайн экологи, соёл, нийгэмд гүйцэтгэж буй үүргийг илүүтэй орлож чадахуйц өөр хувилбарууд болон өөрчлөлтүүд;
- Бор Овоогийн Задгайг нүүлгэн шилжүүлснээр малчдын бэлчээр, усны хангамж болон усны чанарт учирч буй шууд, шууд бус, хам нөлөө.

1-р шатны эцэст ХШБ нь зөвлөмжүүд гарган Хамтран баримт олж тогтоох судалгааны **2-р шатыг** хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулна. 1-р шатанд олж тогтоосон баримтууд дээр үндэслэн мэргэжилтнүүдийн баг нь 2-р шатны ажлын үндэслэл болон төлөвлөлтийн талаар дараахь зүйлсийг багтаасан (гэвч эдгээрээр хязгаарлагдахгүй) зөвлөмжүүд гаргана:

Халив-Дугатын гол болон Ундай голын сав газрын хам нөлөө. Тодруулбал:

- Халив-Дугатын голыг өөрчилсөн эсвэл ирээдүйд өөрчлөх эсэх, Ундай болон Халив-Дугатын голын гольдролыг өөрчилсөнтэй холбоотой тус бүсийн усан хангамж, бэлчээрийн нөөцөд үзүүлэх нийт нөлөөлөл;
- Хаягдал хүдрийг агуулах байгууламжаас шүүрэл гарч буй эсэх, тухайн шүүрлийн ирээдүйн эрсдэл болон тухайн шүүрэл малчдын ундны болон тэдний малын усны эх үүсвэр болох Халив-Дугатын гол болон бусад голд үзүүлж болох нөлөөлөл;
- Халив-Дугатын голд үзүүлэх нөлөөллийг багасгах зорилгоор төслийн хаягдал хүдрийг агуулах байгууламжийг өөрчлөх үндэслэл боломж эсвэл холбогдох хяналт мониторинг, нөлөөллийг бууруулах төлөвлөгөө.

Хэрэглэх арга

Бүхий л оролцогч талуудын хувьд харилцан хариуцлагатай мэдээллийг бий болгох замаар ХШБ нь ажлаа гүйцэтгэнэ. Иймд ХШБ-ийн хамтран баримт олж тогтоох аргачлал нь дараах үндсэн агуулга ухагдахуунд тулгуурлана:

- Бүхий л оролцогч талын итгэл үнэмшлийг бий болгохын тулд ХШБ-ийн үнэлгээний үйл ажиллагаа ил тод, оролцоог хангасан байх
- Аргачлал болон үр дүнгийн талаар маш тодорхой, соёл ба зан заншлын хувьд зохимжтой байдлаар харилцаж танилцуулах
- Асуудлын мөн чанар болон үнэлгээний явцад олж тогтоосон ажиглалтын хувьд төвийг сахисан, шинжлэх ухааны зарчмыг нягт баримтлах

Энэ ажлыг маргааныг хэлэлцээрийн замаар шийдвэрлэхэд талуудыг чиглүүлэх үүргийнхээ хүрээнд ОТ уурхайн санхүүжилтээр САО удирдан чиглүүлж ажиллана. Хөндлөнгийн байр суурьтай байх нөхцлийг бүрдүүлэхийн тулд ХШБ-ийн төлбөрийг САО –оос хийнэ.

Түүнчлэн, ХШБ нь шинжээч гишүүдийнхээ дотоод зөвшилцлийг хангаж асуудалд нэг дуу хоолой, санал илэрхийлж ажиллана. Одоогийн байдлаар ОТ болон малчдын төлөөлөгчид ХШБ-ийн хоёр гишүүн – Стив Бакли, Сабине Шмит нарыг сонгосон бөгөөд ХШБ нь өөрсдөө шаардлагатай байгаа чадавх, туршлага бүхий багийн гурав дахь гишүүнийг нэмж сонгох санал гаргах боломжтой.

Тэмдэглэл: нэр томъёо, тодорхойлолт тайлбарын хавсралтыг ХШБ бэлтгэж, ХШБ-ийн ажлын контекстийн талаарх дундын ойлголтыг хангахын тулд энэхүү баримт бичгийн эцэт нэмж оруулав.

Үйл ажиллагааны явц

Үнэлгээний үйл ажиллагааны гол чухал элементүүд:

- a) үнэлгээний гол алхмуудын талаар талуудын урьдчилсан тохиролцоо,
- b) баримт бичгүүдэд дүгнэлт хийх, газар дээр очиж танилцах, холбогдох талуудтай ярилцлага хийх, ХШБ-ийн үнэлгээ, илэрсэн зүйлс ажиглалтуудийг хамтран дүгнэх цикл.

Асуудлууд нарийн төвөгтэй учраас хамтран баримт олж тогтоох үйл ажиллагаа янз бүрийн асуудлаар харилцан адилгүй хугацаанд хийгдэнэ гэж үзэж байна.

Мэргэжлийн хяналт

Үнэлгээнд шинжлэх ухаанд тулгуурласан мэдээлэл, мэргэжлийн тайлангуудаас гадна байгалийн нөөцийн тогтолцооны талаарх нутгийнхны мэдлэг, туршлага, тэдгээрийн нөхцөл байдал, хандлага, удирдлага, ашиглалт, нутгийнхны амьжиргаанд ямар ач холбогдолтой зэргийг тусгана.

Шинжлэх ухааны болон мэргэжлийн

Үнэлгээний явцад холбогдох бүх инженеринг, ус, хөрс, ургамлын хяналт, шинжилгээ, удирдлагын болон нөлөөллийг бууруулах төлөвлөгөө, тайлан зэрэгт нарийн гүн шинжилгээ хийнэ. Үүнд:

- Гидрологи/геологи, бэлчээрийн газар, говь цөлийн экологи бусад хамаарал бүхий асуудлаар холбогдох талуудын хийсэн буюу тэдний өмнөөс хийгдсэн, орон нутгийн (аймаг, сум) болон засгийн газрын агентлагууд, судалгааны хүрээлэнгүүдэд байгаа мониторингийн мэдээллүүд
- Өнөөг хүртэлх бүх нөлөөллийн үнэлгээний тайлангууд
- Барилгын гүйцэтгэгч гэрээт компаниудын тайлангууд
- Төлөвлөсөн болон одоо хийгдэж буй барилга байгууламжийн нөлөөллийг үнэлэхдээ цаг уурын тоо баримтууд, цаг уурын хандлагын төсөөллийг харгалзан үзнэ.
- Байгаль Орчин, Нийгмийн Нөлөөллийн Үнэлгээний дараа хийгдсэн бүх аудит (ОТ ХШБ-т бүх аудитын материалыг өгнө)

Орон нутгийнхны мэдлэг мэдээлэл, амьжиргаа.

Энэ үнэлгээ нь Ундай голын сав газарт нутагладаг малчдын амжиргаа болон мал аж ахуйн үйлдвэрлэлтэй холбоотой тэмдэглэл баримтуудыг хянаж дүгнэлт зөвлөмж гаргана. Голын гоидрол өөрчилснөөр голын нөхцөл байдалд гарсан өөрчлөлтөөс улбаалан соёлд ямар нөлөө үзүүлсэн, байгалийн баялагийг ашигладаг уламжлалт зан заншил, тухайлбал ус, бэлчээрт гарсан өөрчлөлтийг судална. Байгалийн болон соёлын үнэт зүйл, дурсгалт газруудыг харж хамгаалж, тахин шүтэж ирсэн орон нутгийн уламжлалт заншил болон амжиргааны талаарх мэдээллийг мөн судална. Ингэхдээ малчдын амьдрал ахуйд нөлөөлдөг инфляц гэх мэт нийгэм эдийн засгийн хүчин зүйлсийг харгалзана.

Энэ мэдээллийн эх сурвалжууд нь:

- Орон нутгийн засаг захиргаанд буй тоо баримт, төслийн зорилгоор хийгдсэн суурь судалгаа, нөлөөний үнэлгээнүүд, тусгай барилга байгууламжийн төлөвлөгөөнүүд
- Орон нутгийн малчдын мэдлэг, туршлага орон нутгийн малчин өрх айлуудтай, МТ-тэй хамтад нь болон дангаар уулзалт хийх нь тэдний амьжиргаа, бэлчээрийн мал маллагаа, тэдэнд бэлчээр, ус ямар их чухал болохыг ойлгож мэдэх гол хэрэгсэл байна
- Бор Овоогийн задгайн барилгын ажил эхлэхээс өмнөх нөхцөл байдал ямар байсан талаарх видео / зураг тэмдэглэл. ОТ ХХК эдгээр мэдээлэлтэй үзэж танилцаж боломжийг бүрдүүлнэ.
- Сумын усны мэргэжилтэнтэй зөвлөлдөн сум, аймгийн түвшинд хадгалагдаж байгаа Бор Овоогийн задгайн талаарх гидрологийн мэдээлэл, тэмдэглэл, үндэсний түвшинд байж болох материалууд (NAMEM, усны хэлтэс).

Орон нутагт ажиллах

Орон нутагт ажиллах томилолтын зорилго нь өнөөг хүртэл байгалийн нөөцөд тулгуурлан нүүдэллэж, амьжиргаагаа залгуулдаг нүүдэлчин, малчин ард иргэдийн амьжиргааны өнгөрсөн болон өнөөгийн байдлын талаар нийтлэг ойлголтыг олж авах; ОТ уурхайн үйл ажиллагаатай холбогдолтой хэрэгжүүлсэн болон төлөвлөсөн барилга байгууламжуудын талаар нэгдсэн ойлголттой болох; орон нутгийнхны мэдлэг мэдээлэл, шинжлэх ухаанд тулгуурласан тоо баримт, мөн асуудал үүсгэсэн барилга байгууламжийн төслүүдийн техник хувилбаруудыг хянаж, учирсан буюу гарч болох нөлөөллийг хамтран үнэлэхэд оршино.

Орон нутагт ажиллах үеэр

- Ундайн голын гольдролыг өөрчилсэн хэсэг, уурхайн хэсэг болон барилгын ажил явагдаж буй болон төлөвлөж байгаа газрууд, улирлын шинжтэй бэлчээрийн газар, бэлчээрийн нөөц болон нөлөөлөлд өртсөн малчдын усны эх үүсвэр бүхий газруудаар явж танилцана.
- Томилолтын үеэр урсгалыг өөрчлөх далангийн барилгын ажлын талбай, урсгалыг өөрчлөх суваг, Баруун суваг, төлөвлөгдсөн Урд далан, голын уулзвар, хаягдал чулуулгын овоолгын хэсэгт гол анхаарал тавигдана.
- Бор Овоогийн задгайн талбай, задгай хийхээр санал болгосон байршлын хувилбарууд
- Ундай голын доод салаа нь маш их хайлаас агуулсан бэлчээрийн гол хэсэг бөгөөд энэ газрын ач холбогдол, болзошгүй нөлөөллийг үнэлэхийн тулд зайлшгүй очиж үзэх шаардлагатай.
- 2-р шатны загвар, хэрэгжилтийн тухайд Халив-Дугатын гол, төлөвлөгдсөн хаягдал хүдрийн агуулахын байгууламжийн газар болон хаягдал чулуулгын овоолгыг очиж үзнэ.

Оролцогч талын оролцоо, үүрэг, хариуцлага

Санал болгож буй үйл ажиллагаа нь холбогдох асуудлаар тодруулга авахын тулд оролцогч талуудтай зөвлөнө. Үүнд:

- Нутгийн нүүдэлчин малчид,
- Орон нутгийн засаг захиргааны төлөөлөл, байгууллага
- Төрийн бус байгууллагууд (Говийн газар шороо болон ОТ Хяналт)
- Гомдлын асуудлаар төлөөлөх сонгуульт төлөөлөгчид (МТБ),
- ОТ ХХК, ялангуяа ОТ-н эрх зүйн хяналт хангах, нөлөөллийн үнэлгээ, орон нутгийн харилцаа, төлөвлөлтийг хариуцсан ажилтнууд

Хоёр шатны ажлын төлөвлөгөө, аргачлалын төслийг тодруулга авах зорилгоор оролцогч талуудад танилцуулна.

Баримт бичгүүдийг судалж, танилцан, үндэсний түвшинд буюу Байгаль орчин, Ногоон хөгжлийн яам, Улаанбаатар хот дахь ОТ төв оффис, ОТ Хяналт ТББ-тай анхан шатны уулзалтуудыг хийсний дараа ХШБ нь Ханбогд сумд очин, газар дээр нь малчид, ОТ ажилчидтай уулзан тулгарч буй асуудлуудыг ярилцана. Эхний томилолт нь ХШБ-ийн хувьд орон нутгийн холбогдох бүх талуудад учирч буй гол асуудал болон тэдний байр суурийг ойлгож, хамтарсан ажил хэргийн харилцааг бий болгоход чиглэгдэх юм.

Хамтран баримт олж тогтоох үйл ажиллагаанд орон нутгийн оролцогч талуудын зөвлөлдөөн, оролцоо нь МТБ, нутгийн бусад малчин өрхийн гишүүд, аймаг сумын орон нутгийн засаг захиргааны төлөөлөлтэй хийх уулзалтуудыг хамарна.

Орон нутагт ажиллах нь анхдагч эх үүсвэрээс асуудлыг сонсож дараа нь төв засгийн газрын болон үндэсний түвшний агентлаг, байгууллагууд, ОТ-н Улаанбаатар дахь төвтэй уулзаж баримт бичгийг үргэлжлүүлэн хянах ажлаа үргэлжилэхийн өмнө анхны ойлголттой болох нөхцөл бүрдэнэ.

Аргачлал

Үйл ажиллагааны аргачлалууд нь:

- Болзошгүй нөлөөллийг тооцсон аргачлал ба олж ажигласан зүйлсийн үнэн бодитой эсэхийг үнэлэхийн тулд шинжлэх ухааны судалгааны болон мэргэжлийн тайлангуудад хийсэн дүн шинжилгээ, мөн голын голидрол өөрчлөх төлөвлөгөө болон нөлөөллийг бууруулах төлөвлөгөөнд тусгагдаагүй бусад хувилбаруудыг хянаж шинжлэх.
- Техникийн мэргэжилтэн/ эрдэмтэдтэй хэлэлцүүлэг хийх/ тодруулга авах.
- Хамтран баримт олж тогтоох судалгаанд ашиглах хамтын оролцоот арга хэмжээний арга хэрэгсэл нь орон нутгийн амьжиргаа болон үйлдвэрлэлийн тогтолцооны талаар нийтлэг ойлголтыг бий болгон, нүүдэлчин иргэдийн хувьд бэлчээр, ус хүртээмжтэй байх нь ямар чухал болохыг дэлгэрэнгүй ойлгохын тулд нийгмийн шинжлэх ухааны судалгаа ашиглана. Үүнд зорилтот бүлгийн хэлэлцүүлэг, холимог ярилцлага, түүнчлэн байгалийн баялаг болон нийгмийн байдлын газрын-зураглал, байгалийн баялаг/байгаль орчны өөрчлөлт, хандлага, эрсдэлийн дүн шинжилгээ, амьжиргааны дүн шинжилгээ болон бусад зүйлс багтана.

Нөлөөлөлд өртсөн талууд /Хэвлэл мэдээллийнхэнтэй харилцах, баримтжуулах

Ажлын явцын талаар ХШБ нөлөөлөлд өртсөн талуудад тогтмол мэдээлнэ. Эдгээр явцын тайлан мэдээг англи болон монгол хэлээр аль алинаар нь и-мейлээр буюу биечлэн уулзаж танилцуулна.

Холбогдох ажлын дараа дараагийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх буюу гол гол асуудлаар ХШБ-ийн гаргасан эцсийн шийдвэрийг баримтжуулан дэлгэрэнгүй тайлбар бүхий хуримтлагдсан багц тэмдэглэлтэй болохын тулд ХШБ-ийн үйл ажиллагаа тус бүрийн талаар САО-ийн эвлэрүүлэн зуучлах баг бичгээр тойм (англи, монгол хэлээр) бичиж боловсруулна.

ХШБ нь ажлынхаа явцад хэвлэл мэдээллийн байгууллагаас мэдээлэл хүссэн хүсэлт хүлээн авах магадлалтай. ХШБ нь хэвлэл мэдээллийн хэрэгслийг оролцуулахаар урих ёсгүй. САО-ийн эвлэрүүлэн зуучлах баг ХШБ-ийн өмнөөс хэвлэл мэдээллийнхнээс ирсэн хүсэлт шаардлагад нэн даруй хариу өгнө. Хэвлэл мэдээллийнхнийг ХШБ болон оролцогч талуудын хооронд зохион байгуулагдаж буй олон нийтийн уулзалтанд урихгүй байна.

Ус судлалын ерөнхий нэр томъёо / ТодорхойлолтуудСуваг (*Channel*): Ерөнхий нэр, хүний гараар хийгдсэн эсвэл байгалиасаа оршин байдаг, голдуу ёроол эрэгнүүд бүхий ус урсах ил судал. *Generic term, can be man-made or natural, but generally composed of a bed and banks, an open conduit.*

Идэвхтэй суваг (Active Channel): Усны эргэлтийн дийлэнх хугацаанд ус урсаж байдаг сувгийн хэсэг. Ургамалжилт бараг байдаггүй. *that portion of the channel that flows during the most frequent times of the given hydrologic cycle. Not usually vegetated.*

Эрэг дүүрэн суваг (Bankfull Channel): Суваг үүсгэж буй урсгалаар тодорхойлогддог суваг (гол төлөв 1.5 жилийн үерээс хамааралтай). Идэвхтэй сувгийнх шиг байнгын урсгалгүй ч сувгийн урсгал эргээ дүүрэн урсахдаа ёроолын хагшаас хурдасыг хөдөлгөн зөөдөг (үерийн үенээс доогуур). Эрэг дүүрэн урсгал бүхий сувгийн зарим хэсэг ургамалжилттай байж болно. *The channel defined by the channel-forming flows (generally corresponds to the 1.5 year flood). Though this is not as often as flow in the active channel, but when the channel is full to its banks and doing the most work moving bedload (below flood stage). Parts of the bankfull channel can be vegetated.*

Бага урсгалтай суваг (Low-flow Channel): Эрэг дүүрэн сувгийн хамгийн бага урсгал, энэ нь урсгалын горимоос хамааран янз бүр байдаг. *the minimal flow within the bankfull channel, this will vary depending on flow regime.*

Хүний гараар хийсэн суваг (Man-made Channel): Тодорхой ёроол, эргүүдийн дагуу усыг урсгахаар зохион бүтээгдсэн байдаг. *designed to convey water via a defined bed and banks.*

Урсгалыг өөрчлөх суваг (Diversion Channel): Өөр нэг сувгийн урсгалын чиглэлийг нийтэд нь буюу хэсэгчлэн өөрчлөхөөр зохион бүтээгдсэн суваг, энэ нь түр зуурын эсвэл байнгын байж болно. *designed to divert all or part of the flow from another channel, can be temporary or permanent.*

Үерийн халгиа буюу усанд автах эрэг хавийн газар (**Floodplain**): Эрэг дүүрэн урсгал бүхий сувгийн дагуухь болон чинагш хэсэг. Үерийн халгианы хэлбэр, гүйцэтгэх үүрэг нь урсгалын төрөл, горимоос шалтгаалан янз бүр байна. Үерийн халгиа нь эрэг дүүрэн сувгийн ус дамжуулах чадвараас хэтэрсэн усны зарцуулгатай үед үе үе усанд автдаг. *that area adjacent to, and outside, the bankfull channel. The form and function of the floodplain varies with stream type and flow regime. The floodplain is inundated when the flow exceeds the bankfull discharge.*

Дэнж дэвсэг (Terrace): Өөр цаг уурын урсгалын горимын явцад бий болж орхигдсон үерийн халгиа. Голдуу эрэг дүүрэн сувгаас нэг буюу түүнээс дээш метрийн өндөрт орших хавтгай гадаргуу байдаг. *an abandoned floodplain, constructed in a different climatic flow regime. Usually characterized by a flat surface, a meter or more above the bankfull channel elevation.*

Өөрчлөлт (Diversion): Голын буюу аливаа урсгалын усыг суваг, хоолой, шуудуу руу оруулах. *The taking of water from a stream or other body of water into a canal, pipe, or other conduit.*

Өөрчлөлтийн Далан (Diversion Dam): Усны урсгалыг өөрчилж буй аливаа хиймэл хаалт. *Any artificial barrier which diverts water.*

Хэсэгчилсэн Өөрчлөлт (Partial Diversion): Усны урсгалын зөвхөн аливаа нэг хэсгийг өөрчлөх. *A diversion of only a portion of the water flow.*

Түр өөрчлөлт (Temporary Diversion): Тодорхой хязгаарлагдмал хугацаагаар өөрчлөх. *A diversion that will be of limited duration.*

Түр зуурын урсгал ус (Ephemeral Stream): Бороо хур орсны дараа түр зуур урсдаг урсгал ус. *A stream that flows only briefly after rainfall events.*

Үндсэн урсгал (Main Stem): Урсгал усны тогтолцооны үндсэн суваг. *The principle channel of a stream system.*

Салаа, цутгал (Tributary): Томхон урсгалд нийлж буй багавтар урсгал. *A smaller stream that flows into a larger stream.*

Сүлжилдсэн урсгал (Braided Stream): Урсгал ус замдаа байгаа арал довцогоор салаалан, эргээд урсгалдаа нийлэхийг хэлнэ. Сүлжилдсэн урсгал нь салаа урсгалуудаас тогтоно. *Characterized by successive division and rejoining of stream flow with accompanying islands. A braided stream is composed of anabranches.*

Салаа урсгал (Anabranh): Үндсэн урсгалаасаа салаад эргэн нийлж буй голын салбар. *A diverging branch of a river which re-enters the main stream.***Булаг (Spring):** Газрын гүний ус байгалийн жам тогтолоор хад чулуу эсвэл хөрснөөс ундрэн газрын гадаргууд юмуу гадаргын ус руу орж буй салангид тусдаа газар. *A discrete place where groundwater flows naturally from a rock or the soil onto the land surface or into a body of surface water.*

Нэвчилт (Seep): Газрын гүний ус газрын гадаргуу руу юмуу гадаргын ус руу аажмаар нэвчин орох. *slow flow of groundwater to the land surface or body of water.*

Сэргээх (Restore): Анхны уугуул байдалд нь оруулан засварлах буюу сэргээн босгох. *repair or renovate so as to return to its original condition.*

Дахин бүтээх (Reconstitute): Хэсэг бүлэг(үлдэгдл)ээс дахин барьж байгуулах, сэргээн барих. *to build up again from parts, reconstruct.*

Орлуулах (Replace): Эвдэрч хэмхэрсэн, хуучирсан, ажиллагаагүй болсон зүйлийг орлуулах, нөхөх. *to take the place of or find a substitute for something that is broken, old, inoperative.*

Шинэчлэн бүтээх (Re-create): : Дахин бүтээх, нөхөн бий болгох

Хавсралтууд:

1. Хамтран Баримт Олж Тогтоох Үйл Ажиллагааны тухай

Хамтран баримт олж тогтоох судалгаа - Гол алхмууд, арга хэмжээний дэс дараалал болон урьдчилсан хуваарь

#	Арга хэмжээ	Хийгдэх зүйлс	Хугацаа
1-р шат			
1	Бүх баримт бичиг, тайлангуудыг судалж үзэх (Ундайн голын голидрол өөрчлөлт, Бор овоогийн задгайд төвлөрнө)	1-р шатны ажлын төлөвлөгөө ба аргачлалын төсөл	2013 оны 10 сараас 11 сарын дунд хүртэл
2	Дээд түвшинд танилцах уулзалт хийж ажлын төлөвлөгөөний талаар танилцуулан, шаардлагатай гэж үзвэл дараа дахин уулзах уулзалтыг товлож, холбогдох бүх талууд болон мэдээллийн эх үүсвэрүүдийг хамруулан, уг үйл ажиллагааны талаар мэдээлэл өгч оролцуулна.	Талууд, бүх холбогдох агентлаг, байгууллагууд, мэдээллийн үүсвэрүүдэд мэдээлэл өгч, үйл ажиллагаанд хамруулна.	2013 оны 11 сарын дундуур
3	Орон нутагт ажиллах эхний томилолтоор нөлөөлөлд өртсөн орон нутгийн бүлгүүдтэй зөвлөлдөж, орон нутгийн удирдлагатай уулзан, газар дээр нь нөхцөл байдалтай танилцана. Газар дээр ажиллах эхний томилолтын шатанд 1-р шатны асуудалтай холбогдол бүхий газруудад гол анхаарал хандуулна (Ундай гол, гольдрол өөрчлөх далан, баруун суваг, Урд далан, Бор овоогийн задгайн одоогийн болон нүүлгэн шилжүүлэх боломжит байршил хувилбарууд.) 2-р шатны асуудлуудтай холбоотой газруудаар явж урьдчилан танилцах (Халив-Дугатын сувгийн усны хагалбар, хаягдал хүдрийн агуулахын байгууламж, хаягдал чулуулгын овоолго).	Нөлөөлөлд өртсөн бүлгүүдийн байр суурийг тодорхойлж, зөрүүтэй байдлыг нарийвчлан тогтоох ба оролцогч талуудын дунд нийтлэг ойлголт бий болгох шаардлага байгаа эсэхийг тодорхойлно.	2013 оны 11 сарын дундуур /11 сарын 2-р хагаст
4	Холбогдох чиглэлийн байгууллагуудын (байгаль орны газар, усны газар/агентлаг, хөдөө аж ахуйн газар) мэргэжилтнүүдтэй уулзаж, аймгийн түвшинд мэдээлэл цуглуулах.	Бүх холбогдох агентлаг, байгууллагууд, мэдээллийн үүсвэрүүдэд мэдээлэл өгч, үйл ажиллагаанд хамруулна.	2013 оны 11 сарын дундаас
5	Үндэсний түвшинд Байгаль орчин, Ногоон хөгжлийн яам, холбогдох агентлагууд (Усны газар, Улсын МХГ, Ус, цаг уур, орчны шинжилгээний газар, яам, судалгаа шинжилгээний хүрээлэн (Гео-экологийн хүрээлэн, Цөлжилтийн судалгааны төв болон	Шаардлагатай мэдээлэл/тоо баримтыг цуглуулан, баталгаажуулаад мэргэжлийн шинжээч/эрдэмтэдтэй хамтран хянаж, тодруулсан байна.	2013 оны 11 сарын сүүл 12 сарын эхээр

	бусад шаардлагатай газрууд) болон нөлөөллийн судалгаа, үнэлгээний ажилд (WCS, TNC, болон бусад) оролцож буй үндэсний болон олон улсын ТББ-ууд, нөлөөллийн үнэлгээ, анхан шатны судалгаа, мониторингт оролцсон зөвлөхүүд/компаниуд, барилга байгууламжийн зураг төсөл, хэрэгжилтийг гүйцэтгэсэн гэрээлэгч пүүс, компаниудтай уулзалт хийх.		
6	Эхний томилолтын ажил, уулзалтуудыг дүгнэж, урьдчилсан тайлан бэлтгэх	Илрүүлсэн зүйлсийн жагсаалт, шаардлагатай үнэлгээнүүд, мэдээллийн цоорхой, хэрэгцээ, холбогдох талуудыг оролцуулах боломжууд, харилцан мэдээлэл солилцох, тодруулж тайлбарлах, нөлөөллийн үнэлгээг хийхэд шаардлагатай асуудлууд, дараагийн арга хэмжээнүүдийг тусгасан урьдчилсан тайлан	2013 оны 12 сарын сүүл/2014 оны 1 сарын эхээр
7	Тайланг Монгол хэл рүү орчуулан, мэргэжлийн хэллэгтэй танилцуулгыг мэргэжлийн бус хэллэгт хөрвүүлэн бэлтгэнэ. Тайлан/танилцуулгын төслийг дараагийн уулзалтаас өмнө холбогдох талуудад тараана.	Тайлан монгол хэлээр; энгийн хэллэгтэй танилцуулга.	2014 оны 1 сарын дундуур
8	2 дахь удаагийн орон нутагт ажиллах томилолт: илэрсэн зүйлсийн талаар танилцуулга хийн, тэдгээрийг холбогдох талуудтай хэлэлцэж, шаардлагатай газарт тодруулга хийх; холбогдох талуудтай цаашдын төлөвлөгөөг тохиролцох. “1-р шатны асуудлуудтай холбоотой газруудад” дахин очиж үзэх	Урьдчилсан тайлан, олж илрүүлсэн зүйлсийг оролцогч талуудад тайлбарлаж, тодорхой болгосон байна.	Цагаан сарын дараа буюу 2 дугаар сарын дундуур
9	Энэ томилолтын үеэр: 2-р шатны асуудлуудтай холбоотой газрууд (Халив-Дугатын сувгууд, хаягдал хүдрийн агуулахын байршил) дээр очиж танилцан, Халив-Дугатын сувгууд, бэлчээрийн нөөц, усан хангамж, усны чанарт үзүүлсэн нөлөөлөл болон эдгээр гурван үйл ажиллагаанаас үүссэн (Ундай голын гольдролын өөрчлөлт, Бор овоогийн задгайн орлуулалт, хаягдал	2-р шатанд судлах гол асуудлууд болон 2-р шатанд хийгдэх ажлын цар хүрээг тодорхойлсон байна.	2014 оны 3 сарын эхээр

	хүдрийн агуулахын байгууламж ба хаягдал чулуулгын цэг) нийт хам нөлөөний үнэлгээг эхлүүлэх		
10	1-р шатны эцсийн тайлан/зөвлөмжүүдийг бэлтгэх	1-р шатны ажлын эцсийн тайлан/зөвлөмжүүд. Төслийг талуудад хүргэх	2014 оны 3 сарын сүүлээр
11	2-р шаттай асуудлуудтай холбоотой тайлан/баримт бичгүүдийг үзэж дүгнэлт хийх. 2-р шатны ажлын зураглал/судалгааны ажлын загварыг бэлтгэж эхлэх.		2014 оны 4 сар
12	3 дахь удаагийн хамтарсан томилолт – а) олж мэдсэн зүйлийг эцэслэн гаргаж 1-р шатны зөвлөмжүүд/тохиролцооны хэрэгжилтийг төлөвлөх; б) 2-р шатны асуудлуудтай холбоо бүхий газрудаар явах (Халив-Дугатын сувгууд, хаягдал хүдрийн агуулахын байгууламж ба хаягдал чулуулгын цэг) 2-р шатны гол асуудлуудаар холбогдох талуудтай ярилцаж, тодруулах; ямар мэдээлэл дутагдаж буйг тодруулах, 2-р шатанд баримт мэдээлэл олж тогтоох ажлуудыг төлөвлөх.	2-р шатны Ажлын төлөвлөгөө, Аргачлал (төслийг талуудад хүргэх)	2014 оны 4 сар
13	2-р шатны Ажлын төлөвлөгөө, Аргачлалыг талуудтай хэлэлцэх уулзалтууд	2-р шатны Ажлын төлөвлөгөө, Аргачлал (талуудтай хэлэлцэний дараа дахин хянасан байдлаар)	2014 оны 4 сар
14	1-р шатны эцсийн тайлан/зөвлөмжүүд, 2-р шатны төлөвлөгөөг бэлтгэх	1-р шатны ажлын эцсийн тайлан, 2-р шатны Ажлын төлөвлөгөө, Аргачлал батлагдсан байна.	2014 оны 5 сар

ХАМТРАН БАРИМТ ОЛЖ ТОГТООХ (ХБОТ) ҮЙЛ АЖИЛЛАГАА⁴

ХБОТ гэж юу вэ?

Хамтран баримт олж тогтоох гэдэг нь шинжлэх ухааны судалгаа хийх буюу хийгдсэн судалгаануудын найдвартай, үнэн зөв эсэхийг оролцогч талуудад нотолж өгөхийн тулд хянан шинжлэх үйл ажиллагаа юм. Оролцогч талууд бие биеийнхээ баримт нотолгоог үгүйсгэн, маргаантай асуудлаар шийдвэр гаргахдаа нөгөө талын ашигласан баримтанд үл итгэх буюу санал нийлэхгүй байх тохиолдолд ХБОТ-ыг зөвлөдөг. Сөргөлдөөнтэй байр суурь эсвэл үйлдлийг дэмжих буюу эсэргүүцэхээр тодорхой шинжлэх ухааныг ашигладаг “өмгөөллийн шинжлэх ухааны” эсрэг ерөндөг нь ХБОТ үйл ажиллагаа юм.

“Өмгөөллийн шинжлэх ухаан” нь (ХБОТ-оос эсрэгээр) хууль, шүүхийн өмнө шинжээч гэрчүүд өөрийн баримт нотолгооны “үнэн зөвийг”, нөгөө талын мэдээ баримт эсвэл мэргэжилтнүүд нь хичнээн сул дорой болохыг гэрчлэн мэдүүлэхийг хичээсэн хатуу тэмцэл бүхий мэтгэлцээн рүү хөтөлдөг. Дийлэнх тохиолдолд талууд нэг нэгнийхээ магадлагаа нотолгооны найдвартай бодитой байдалд итгэдэггүй. Эцсийн дүнд нотолгоо баримт үнэн зөв эсэх, тоо баримт, шинжилгээ, тайлбар тодорхойлолтуудыг урьдчилан хүссэн байдалдаа оруулахын тулд гажуудуулсан эсэх талаар маш их эргэлзээ үүснэ. Аль аль талыг нь баримтлахгүй байгаа олон нийт “шинжлэх ухаан” хүчрэхгүй юм байна гэсэн бодолтой хоцордог.

Өмгөөллийн шинжлэх ухаан руу ханддаг нь сэтгэл зүйч нотлох талдаа хэвийх гэж хэлдэг шиг өөрийн төсөөлөл, үнэмшлийг батлахуйц байдлаар мэдээлэл хайх буюу тайлбарлахаар хөөцөлдөж буй хэрэг. Нотлох талдаа хэвийх гэдэг нь хүмүүс өөрсдийн таамаглалыг батлахад илүү ач холбогдол өгч тэр таамаглалыг нь үгүйсгэх баталгааг үл тоомсорлох буюу огт

оролцохыг хүсдэг.

Энэ нь эрдэмтэд, шийдвэр гаргагчид, иргэдийг нааштай харилцаанд оруулдаг уян хатан үйл ажиллагаа тул тэдгээрийн хоорондын харилцааг сайжруулж, баримт мэдээллийн талаарх санал зөрөлдөөнийг багасгадаг. Судалгааны асуулга боловсруулах, эцэст нь гаргах шийдвэр болон авах арга хэмжээг тодорхойлоход үндэс болж өгөх шинжлэх ухаан, техникийн мэдээллийг тогтоох, цуглуулах, дүгнэн шинжлэх, тайлбарлах үйл ажиллагаанд аливаа шийдвэрийн улмаас нөлөөлөлд өртөгсдийг мөн оролцуулна.

ХБОТ үйл ажиллагаа уян хатан хэдий ч дараахь **гол зургаан шинжийг** агуулдаг.

- (1) Өөр өөр үзэл бодол, байр суурь бүхий хэд хэдэн оролцогчдыг хамардаг;
- (2) тэд хоорондоо хамтран ажиллаж, бусдыг ч хамтран ажиллахыг шаардана;
- (3) тэд зохион байгуулалт сайтай, өөрөөр хэлбэл ХБОТ үйл ажиллагаа, уулзалтуудыг зөнд нь орхихгүй, сайн боловсруулан, тодорхой асуудалд төвлөрөн яриа хэлцэл хийнэ;

⁴ “Эгэл Баримт. Хамтран баримт олж тогтоох – Шинжлэх ухаан, Бодлого, Олон нийтийг хамтруулах стратеги” Питер С. Адлер, PhD; Тод Брайн, PhD; Метью Мулика, MS; Жули Шатино, MS

- (4) тэд баримтанд тулгуурлан, асуудлыг олон өнцгөөс, эрүүл саруул ухаанаар шинжлэн судална;
- (5) энэ нь эрх ашигт суурилсан судалгааны үйл явц болохоос улс төрийн байр сууриар мэтгэлцэх талбар биш; мөн
- (6) энэ нь нэгдмэл цогц, олон талт. Тэд төрөл бүрийн мэдлэг, мэдээлэл, тоо баримтыг нэг дор авчирна.

ЭЦС ИЙН ХУВИЛБАР